**1.** Нийтийн тоолол (НТ) нь хэрхэн тоологддог вэ?
A. Ихээсээ бага руугаа (3, 2, 1)
B. Жилийг 12 амьтнаар төлөөлүүж
C. Багаасаа их рүүгээ (1, 2, 3)
D. Зурхайн 12 ордоор төлөөлүүлж

**2.** Эртний хүмүүсийн амьдралын ул мөрийг хадгалсан аливаа зүйлсийг юу гэдэг вэ?
A. Түүхийн үечлэл
B. Түүхийн эх сурвалж
C. Түүхийн он цаг
D. Түүхийн сургамж

**3.** Он тооллын шугамыг уншиж асуултад хариулна уу.




A. 75 жил
B. 25 жил
C. 51 жил
D. 26 жил

**4.** НТӨ 2026 он хэддүгээр мянганы, аль хагаст хамаарах вэ?
a. III мянган, II хагас
b. II мянган, II хагас
c. II мянган, I хагас
d. III мянган, I хагас

**5.** 3.5 сая жилийн өмнө амьдарч байсан эмэгтэй хүнийг араг яс аль тивээс олдсон бэ?


Люси




A. Америк тив
B. Европ тив
C. Ази тив
D. Африк тив

**6.** Доорх зургийг ажиглан цэгийн оронд тохирох үгийг сонгон уу.




A. Ан агнуур
B. Газар тариалан
C. Загасчлал
D. Хүрэл зэвсэг

**7.** Неолитын хувьсгал гарснаар хүмүүсийн амьдралд ямар шинэ өөрчлөлт гарсан бэ?
A. Нүүдэллэн явах нь нэмэгдсэн.
B. Даавуу нэхэж, ваар урлах болсон.
C. Олзворлох түүвэрлэх аж ахуй нэмэгдсэн.
D. Ан агнуур хийх нь нэмэгдсэн.

**8.** Доорх зурган дээр ваарыг хэв ашиглах аргаар хийж буй үйлдэл аль нь вэ?

A.  B.  C.  D. 

**9.** “Суурин иргэншил” үүссэн анхны голомт нутгийг сонгоно уу.

A. Орхон голын хөндий B. Амазон мөрний хөндий
C. Хоёр мөрний хөндий D. Ижил мөрний хөндий

**10.** Доорх зурган ямар бичгийн төрлийг харуулж байна вэ?




A. Шаантаг бичиг B. Авиан бичиг C. Санаа бичиг D. Кирил бичиг

**11.** Хүрэл зэвсгийн шинж чанартай холбоотой тодорхойлолт аль нь вэ?

A. Бага хэмд хайлдаг уян зөөлөн
B. Гялалзсан цагаан өнгөтэй бага хэмд хайлдаг
C. Өндөр хэмд хайлдаг, хатуу бат бөх
D. Зэс, цагаан тугалагийн холимог

**12.** Доорх зураг нь ямар бичгийг илэрхийлж байна вэ?



A. Шумерийн шаантаг бичиг
B. Грекийн санаа бичиг
C. Финикийн үет авиан бичиг
D. Египетийн дүрс бичиг

**13.** Уг түүхэн дурсгалд хамаарах тодорхойлолтыг сонгоно уу.




A. Монголын хүрэл зэвсгийн үед хамаарна. Дөрвөлжин, дугуй хүрээ чулуутай, оршуулга ба тахилгын зориулалтай овоолго чулуун байгууламж.
B. Монголын хүрэл зэвсгийн үед хамаарна. Дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу бүхий оршуулгын байгууламж.
C. Монголын хүрэл зэвсгийн үед хамаарна. Гонзгой урт чулууг засаж өнгөлөн, дээд хэсэгт нар, сар хөшөөний их биеийг ороолгон бугын дүрсэлсэн хөшөө.
D. Зэрлэг араатан, адуу, үхэр, тэмээ, домгийн амьтдыг донжтой гоёмсогоор хийсвэрлэн дүрслэх урлаг.

**14.** Доорх бүдүүвчийг ажиглан эртний хоёр мөрний улсын нийгмийн давхарга аль нь вэ?




A.

| |
|---|
| a. Санваартнууд |
| b. Цэргийн жанжид, язгууртнууд |
| c. Тариачид, урчууд, худалдаачид |
| d. Газаргүй тариачид, боолууд |

B.

| |
|---|
| a. Фараон |
| b. Тэргүүн тахилч, захирагч |
| c. Урчууд, |
| d. Тариачид |

C.

| |
|---|
| a. Хаан |
| b. Чөлөөт иргэд (түшмэд, тахилч, бичээч) |
| c. Хагас чөлөөт иргэд (тариачид, малчид, урчууд) |
| d. Боол |

D.

| |
|---|
| a. Хаан |
| b. Ахмадын зөвлөл, 5 эфор |
| c. Иргэдийн хурал |
| d. Боол |

**15.** Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу.
.................... хүүхдийг 7 нас хүртэл эх нь өсгөөд дээд давхаргын хөвгүүд сургуульд сурна. Тэд сургагч боолын хяналтад сургадаг.

A. Спартууд  B. Египетэд  C. Афинд  D. Ромчууд

**16.** Эртний нэгэн улс томоохон байгууламж барихад 2,4 сая гаруй бул чулуу ашиглаж ямар байгууламж барьсан бэ?
(Бул чулууны тус бүрийн жин нь судлаачдын үзэж байгаагаар дундажаар 2,5-15 тонн хүртлэх байв.)
A. Цагаан хэрэм
B. Хуфугийн пирамид
C. Кукулкан /Эль Кастило/ сүм
D. Хафрегийн пирамид

**17.** Эртний Энэтхэгийн кастын тогтолцоонд цэргийн жанжид, язгууртнуудыг юу гэж нэрлэдэг вэ?
A. Вайши
B. Кшатри
C. Шудра
D. Брахман

**18.** Цэгийн оронд тохирох үгийг сонгон уу.
НТӨ 800 оны орчим Тибер голын хөвөөнд Лациум хэмээх талд долоон толгод оршино. Тэнд малчин, тариачдын суурин, тосгон бий болов. Тэдгээрээс хамгийн чухал нь Палатин хэмээх толгой байв. Түүн дээр ............... тосгон оршиж байв. ............... аажмаар томорч, хүчирхэг хот болжээ.
A. Спарт
B. Афин
C. Мемфис
D. Ром

**19.** Он тооллын шугамыг уншиж, асуултад хариулаарай.




a. Цин улс, 14 жил
b. Хан улс, 426 жил
c. Ся улс, 426 жил
d. Шан улс, 644 жил

**20.** Доорх бүтээлүүдийг улс бүрт нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| a. Цинь улс |  1. |
| b. Жоу улс |  2. |
| c. Хан улс |  3. |
| d. Шан улс | 4.  |

A. a-3,b-4,c-2,d-1 B. a-3,b-2,c-4,d-1 C. a-2,b-3,c-4,d-1 D. a-1,b-4,c-2,d-3

**21.** Дараах улсуудын нийгмийн бүтэцийг зөв харгалзуулна уу.

<table>
<tr>
<td>a. Ромын хаант улс</td>
<td>1. 
</td>
</tr>
<tr>
<td>b. Афины хот улс</td>
<td>2. 
</td>
</tr>
<tr>
<td>c. Ромын Бүгд Найрамдах улс</td>
<td>3. 
</td>
</tr>
</table>

<table>
<tr><td>d. Спартын хот улс</td><td>4. 
</td></tr>
</table>

A. a-1,b-4,c-2,d-3 B. a-2,b-4,c-3,d-1 C. a-2,b-3,c-4,d-1 D. a-3,b-4,c-2,d-1

**22.** Дунху болон Юэжиг эзэлж, цэрэг-засаг захиргааны аравтын тогтолцоог хэн анх үндэслэж хэрэгжүүлсэн бэ?
A. Модунь шаньюй B. Түмэн шаньюй
C. Зижү шаньюй D. Зүнчэн шаньюй

**23.** Уг олдвор ямар улсын түүхэнд холбогдох олдвор вэ?



Архангай аймаг, Өндөр-Улаан сум, Гол модны XX булшны олдвор. Бэлгэт гөрөөс.

A. Түрэг гүрний эд өлгийн сурвалж
B. Сяньби гүрний эд өлгийн сурвалж
C. Жужан гүрний эд өлгийн сурвалж
D. Хүнну гүрний эд өлгийн сурвалж

**24.** Модунийг шаньюй болмогц улс төрийн дарамт шахалт үзүүлж хурдан хүлэг, хайртай хатан болон газар нутгаа өгөхийг шаардсан улс нь аль вэ?
A. Юэжи B. Усунь C. Динлин D. Дунху

**25.** НТӨ 48 онд Хүннүгийн дотор хаан ширээний төлөө тэмцэл өрнөж өмнөд, умард хэмээн хоёр хэсэгт хуваагдав. Уг үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
A. 1978 жилийн өмнө B. 2074 жилийн өмнө
C. 2234 жилийн өмнө D. 1816 жилийн өмнө